



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/411

Улаанбаатар хот

Хүнсний зориулалтын бус
хуванцар савны хэрэглээг бууруулах
аян зохион байгуулах тухай.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдаа, Хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020” нийслэлийн дэд хөтөлбөрийн 2.2.5, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/169 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 2019 оны Б/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын баталсан “Сав баглаа боодол үндэсний хөтөлбөрийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөө”-ний 9 дэхь заалтын дагуу хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах аяныг 2019 оны 07 дугаар сарын 01-нээс 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга /Э.Сансар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн
А/411 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Э.Батбилэг	Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч бөгөөд Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга
Гишүүд:	Э.Сансар	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	А.Одонтунгалагтуул	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	-	Статистикийн хэлтэс
	Б.Нарангэрэл	Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга
	23 хороо	Хороодын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга:	Б.Бат-Өлзий	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн